

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



## АУДИТЫН ТАЙЛАН

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/002/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас: <a href="http://www.audit.mn">www.audit.mn</a> Улаанбаатар хот 2026 он	Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор : Г.Нандинжаргал Утас: 7000-7734 Цахим хаяг: <a href="mailto:nandinjargalq@audit.gov.mn">nandinjargalq@audit.gov.mn</a> Санхүү, нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:tuvshinbayarkh@audit.gov.mn">tuvshinbayarkh@audit.gov.mn</a> Аудитын менежер: Д.Отгонбаяр Утас: 315558 Цахим хаяг: <a href="mailto:altantsetsegya@audit.gov.mn">altantsetsegya@audit.gov.mn</a> Ахлах аудитор: Г.Долгорсүрэн Утас: 325093 Цахим хаяг: <a href="mailto:battagoon@audit.gov.mn">battagoon@audit.gov.mn</a>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
**НИЙСЛЭЛ ДЭХ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Соёлын төв өргөө Г корпус, 5 давхар,  
А.Амарын гудамж, 8 дугаар хороо,  
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200  
Утас: (976) 7000 7734, Факс: (976-11) 32 01 54  
Цахим шуудан: Ub@audit.gov.mn,  
Цахим хуудас: www.audit.mn

2026-03-25

№

1025

танай

-ны №

-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ  
ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА  
Г.ЖАРГАЛСАЙХАН ТАНАА

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Баянзүрх дүүргийн 2025 оны төсвийн орлогын төлөвлөгөөг 374,786.8 сая төгрөг төвлөрүүлэхээр баталснаас гүйцэтгэлээр 339,426.7 сая төгрөг буюу 35,360.1 сая төгрөгөөр тасарсан байна.

### Аудитын гол асуудал

Баянзүрх дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас төсвийг санхүүжүүлэх эх үүсвэрийг 381,360.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд нийслэлийн төсөвт өөрчлөлт орсон болон дүүргийн орлогын төлөвлөгөөний биелэлтээс шалтгаан дүүргийн төсвийг 379,093.1 сая төгрөгөөр буюу 2,266.9 сая төгрөгөөр бууруулж тодотгосон байна.

### Бусад асуудлын хэсэг

Дүүргийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны үйл ажиллагааны хөтөлбөрт 5 зорилтын хүрээнд 172 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 90.8

1426050935

C:\Users\arangua\Desktop\Бичр хэрг... 2026/03/25 10:23:11

хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

#### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, нэгдсэн төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

## 2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>71,438,910.4</b>	<b>105,252,379.7</b>
2	<b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>	18,315,313.3	40,939,199.5
3	АВЛАГА	773,748.4	556,545.7
4	УРЬДЧИЛГАА	1,956,238.6	16,540,323.7
5	БАРАА МАТЕРИАЛ	4,711,236.3	11,103,914.0
6	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	45,682,373.8	36,112,396.9
7	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>210,276,785.4</b>	<b>228,198,794.2</b>
8	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>210,276,785.4</b>	<b>228,198,794.2</b>
9	Биет хөрөнгө	169,928,829.9	187,887,473.0
10	Биет бус хөрөнгө	40,347,955.5	40,311,321.2
11	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2</b>	<b>281,715,695.8</b>	<b>333,451,173.9</b>
12	НИЙТ ӨР ТӨЛБӨР	15,117,039.0	14,160,836.6
13	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	15,117,039.0	14,160,836.6
14	Өглөг	7,746,654.1	6,458,634.9
15	Урьдчилж орсон орлого	7,370,384.9	7,702,201.7
16	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>266,598,656.8</b>	<b>319,290,337.4</b>
17	Засгийн газрын хувь оролцоо	266,598,656.8	319,290,337.4
18	Засгийн газрын оруулсан капитал	36,726,992.5	36,726,992.5
19	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	203,887,832.0	256,964,962.9
20	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	25,983,832.3	2,598,382.0
21	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5</b>	<b>281,715,695.8</b>	<b>333,451,173.9</b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН</b>	<b>374,847,517.4</b>	<b>354,374,589.4</b>
2	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>301,027,794.1</b>	<b>334,821,605.5</b>
3	Орлогын албан татвар	254,644,484.3	286,397,122.2
4	Хувь хүний орлогын албан татвар	254,644,484.3	286,397,122.2
5	Хөрөнгийн албан татвар	14,093,633.1	17,325,085.7
6	Бусад татвар, төлбөр, хураамж	32,289,676.7	31,099,397.7
7	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	51,595,467.7	19,552,983.9
8	Тусламжийн орлого	-	4,298,556.5
9	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,224,255.7	-
10	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>328,086,274.8</b>	<b>298,424,747.4</b>

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>11</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>328,086,274.8</b>	<b>296,252,043.3</b>
12	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	188,563,382.2	162,013,343.5
13	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	35,336,250.5	38,631,207.9
14	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,261,429.3	5,362,550.2
15	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14,927,169.2	17,466,185.0
16	Хангамж, бараа материалын зардал	26,457,167.7	27,718,945.2
17	Нормативт зардал	145,771.2	91,104.0
18	Эд хогшил, урсгал засварын зардал	11,928,576.8	6,181,767.2
<b>19</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>486,423.3</b>	<b>524,192.7</b>
20	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	69,614,789.7	21,007,347.9
21	Бараа үйлчилгээний бусад зардал	25,405,804.4	45,030,043.5
22	ТАТААС	162,703.4	-
23	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	139,360,189.3	134,238,699.8
<b>24</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>-</b>	<b>2,172,704.1</b>
25	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	46,761,242.6	55,949,842.0
26	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	18,080,216.9	5,667,616.6
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	(18,080,216.9)	(5,667,616.6)
<b>28</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)</b>	<b>28,681,025.7</b>	<b>50,282,225.4</b>

### 2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
<b>1</b>	<b>2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	238,004,377.1	238,004,377.1
<b>2</b>	<b>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт</b>	(151,792.0)	(151,792.0)
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	237,852,584.0	237,852,584.0
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	65,047.0	65,047.0
5	Тайлант үеийн үр дүн	28,681,025.7	28,681,025.7
<b>6</b>	<b>2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>266,598,656.8</b>	<b>266,598,656.8</b>
7	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	<b>266,598,656.8</b>	<b>266,598,656.8</b>
8	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	2,794,905.6	2,794,905.6
<b>9</b>	<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	269,393,562.3	269,393,562.3
10	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(385,450.3)	(385,450.3)
11	Тайлант үеийн үр дүн	50,282,225.4	50,282,225.4
<b>12</b>	<b>2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл</b>	<b>319,290,337.4</b>	<b>319,290,337.4</b>

## 2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН</b>	<b>365,087,963.0</b>	<b>352,153,973.9</b>
<b>2</b>	<b>ТАТВАРЫН ОРЛОГО</b>	<b>301,027,794.1</b>	<b>334,821,605.5</b>
3	Орлогын албан татвар	254,644,484.3	286,397,122.16
4	Хөрөнгийн албан татвар	14,093,633.1	17,325,085.66
5	Бусад татвар, төлбөр, хураамж	32,289,676.7	31,099,397.66
6	Бусад нийтлэг төлбөр, хураамж	13,169,636.1	10,006,146.15
7	Газрын төлбөр	19,120,040.5	21,093,251.51
<b>8</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>41,661,120.3</b>	<b>17,332,368.4</b>
9	Нийтлэг татварын бус орлого	36,427,413.7	8,768,459.40
10	Тусламжийн орлого	-	4,298,556.47
11	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	5,233,706.6	4,265,352.57
12	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	22,399,048.6	-
<b>13</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>305,430,564.6</b>	<b>286,768,616.2</b>
14	УРСГАЛ ЗАРДАЛ	305,430,564.6	286,768,616.2
15	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,306,233.1	152,650,447.7
16	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	34,026,809.9	38,795,821.48
17	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,268,174.1	5,350,538.76
18	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	15,030,020.9	17,445,132.25
19	Хангамж, бараа материалын зардал	22,220,103.7	28,791,271.69
20	Нормативт зардал	140,974.8	63,196.13
21	Эд хогшил, урсгал засварын зардал	8,891,352.6	5,881,419.28
22	Томилолт, зочны зардал	469,010.5	492,721.91
23	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,471,839.3	34,175,866.40
24	Бараа үйлчилгээний бусад зардал	6,787,947.4	21,654,479.83
25	ТАТААС	162,703.4	-
26	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	147,961,628.1	134,118,168.42
27	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	59,657,398.4	65,385,357.75
28	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	80,100,792.2	42,761,471.5
29	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	80,100,792.2	42,761,471.5
30	Дотоод эх үүсвэрээр	80,100,792.2	42,761,471.54
31	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(80,100,792.2)	(42,761,471.54)
32	Бусад эх үүсвэр	28,378.8	-
33	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	8,950.0	-
34	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	19,428.8	-
<b>35</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>(20,423,965.0)</b>	<b>22,623,886.21</b>
36	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	38,739,278.3	18,315,313.28
37	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	18,315,313.3	40,939,199.49

## 2.5 Аудит хийсэн нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	<b>НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН</b>	<b>379,093,122.4</b>	<b>343,692,043.8</b>	<b>35,401,078.6</b>	<b>90.7</b>
2	<b>Татварын орлого</b>	<b>369,919,806.1</b>	<b>334,821,605.5</b>	<b>35,098,200.6</b>	<b>90.5</b>
3	Орлогын албан татвар	314,518,206.1	286,397,122.2	28,121,083.9	91.1
4	Хувь хүний орлогын албан татвар	314,518,206.1	286,397,122.2	28,121,083.9	91.1
5	Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлого	216,118,206.1	195,673,105.8	20,445,100.3	90.5
6	Үйл ажиллагааны орлого	8,400,000.0	8,705,872.0	(305,872.0)	103.6
7	Хөрөнгийн орлого	19,000,000.0	23,200,451.7	(4,200,451.7)	122.1
8	Хөрөнгө борлуулсны орлого	34,000,000.0	29,526,077.1	4,473,922.9	86.8
9	Шууд бус орлого	37,000,000.0	29,291,615.5	7,708,384.5	79.2
10	Хөрөнгийн албан татвар	<b>18,636,170.7</b>	<b>17,325,085.7</b>	1,311,085.0	93.0
11	Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	18,541,830.7	17,230,165.2	1,311,665.5	92.9
12	Бууны албан татвар	94,340.0	94,920.5	(580.5)	100.6
13	Бусад татвар, төлбөр, хураамж	36,765,429.3	31,099,397.7	5,666,031.6	84.6
14	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,150,000.0	10,006,146.2	6,143,853.9	62.0
15	Улсын тэмдэгтийн хураамж	7,000,000.0	2,149,265.0	4,850,735.0	30.7
16	Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	350,000.0	177,670.3	172,329.7	50.8
17	Хог хаягдлын үйлчилгээний хураамж	8,800,000.0	7,679,210.8	1,120,789.2	87.3
18	Газрын төлбөр	20,615,429.3	21,093,251.5	(477,822.2)	102.3
19	Газрын төлбөр	20,615,429.3	21,093,251.5	(477,822.2)	102.3
20	Татварын бус орлого	<b>9,173,316.3</b>	<b>8,870,438.3</b>	302,878.0	96.7
21	Нийтлэг татварын бус орлого	4,867,000.0	4,605,085.7	261,914.3	94.6
22	Торгуулийн орлого	4,500,000.0	4,100,798.4	399,201.6	91.1
23	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	310,000.0	372,263.1	(62,263.1)	120.1
24	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	57,000.0	71,490.9	(14,490.9)	125.4
25	Бусад орлого	-	60,533.4	(60,533.4)	-
26	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	4,306,316.3	4,265,352.6	40,963.7	99.0
27	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас шилжүүлсэн орлого	4,306,316.3	4,265,352.6	40,963.7	99.0
28	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>381,001,814.6</b>	<b>322,122,412.0</b>	<b>58,879,402.6</b>	<b>84.5</b>
29	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>323,573,383.4</b>	<b>284,817,268.9</b>	<b>38,756,114.5</b>	<b>88.0</b>
30	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>173,487,234.3</b>	<b>150,724,904.5</b>	<b>22,762,329.8</b>	<b>86.9</b>
31	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	28,887,330.7	26,689,566.3	2,197,764.4	92.4
32	Үндсэн цалин	9,067,273.3	8,578,382.5	488,890.8	94.6
33	Нэмэгдэл	2,740,548.1	2,617,094.5	123,453.6	95.5
34	Унаа хоолны хөнгөлөлт	4,010,544.0	3,569,023.1	441,520.9	89.0
35	Урамшуулал	1,887,491.9	743,627.6	1,143,864.3	39.4
36	Гэрээт ажлын хөлс	11,181,473.4	11,181,438.6	34.8	100.0
37	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	3,635,635.9	2,693,603.5	942,032.4	74.1
38	Тэтгэврийн даатгал	2,472,216.8	1,973,132.1	499,084.7	79.8
39	Тэтгэмжийн даатгал	290,854.7	262,105.3	28,749.4	90.1
40	ҮОМШӨ-ний даатгал	145,956.3	108,332.5	37,623.9	74.2
41	Ажилгүйдлийн даатгал	145,274.3	101,054.9	44,219.4	69.6
42	Эрүүл мэндийн даатгал	581,333.8	248,978.7	332,355.1	42.8
43	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	23,599,995.6	17,137,518.7	6,462,477.0	72.6
44	Гэрэл, цахилгаан	10,256,837.8	8,057,179.6	2,199,658.2	78.6
45	Түлш, халаалт	8,210,326.3	5,080,485.8	3,129,840.5	61.9
46	Цэвэр, бохир ус	3,810,561.0	2,682,642.9	1,127,918.1	70.4
47	Байрны түрээс	1,322,270.5	1,317,210.4	5,060.1	99.6

**Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан**

48	Хангамж, бараа материалын зардал	20,263,144.6	19,844,535.1	418,609.5	97.9
49	Бичиг хэрэг	389,386.7	310,762.6	78,624.1	79.8
50	Тээвэр, шатахуун	187,610.0	97,755.0	89,855.0	52.1
51	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	177,775.7	148,747.0	29,028.7	83.7
52	Ном, хэвлэл	33,000.0	22,425.0	10,575.0	68.0
53	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	18,657,815.7	18,583,554.0	74,261.7	99.6
54	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	817,556.5	681,291.6	136,264.9	83.3
55	Нормативд зардал	32,000.0	3,440.0	28,560.0	10.8
56	Нормын хувцас, зөөлөн эдлэл	32,000.0	3,440.0	28,560.0	10.8
57	Эд хогшил, урсгал засварын зардал	7,571,193.9	5,934,344.9	1,636,849.0	78.4
58	Багаж, техник, хэрэгсэл	606,900.0	162,296.9	444,603.1	26.7
59	Тавилга	241,076.0	46,944.7	194,131.3	19.5
60	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	3,000.0	-	3,000.0	-
61	Урсгал засвар	6,720,217.9	5,725,103.3	995,114.6	85.2
62	Томилолт, зочны зардал	1,022,525.0	492,721.9	529,803.1	48.2
63	Гадаад албан томилолт	640,725.0	291,868.9	348,856.2	45.6
64	Дотоод албан томилолт	9,200.0	-	9,200.0	-
65	Зочин төлөөлөгч хүлээн авах	372,600.0	200,853.1	171,746.9	53.9
66	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	64,682,547.9	56,234,409.3	8,448,138.6	86.9
67	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	64,502,609.8	56,141,643.5	8,360,966.3	87.0
68	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,000.0	3,000.0	-	100.0
69	Даатгалын үйлчилгээ	21,950.0	6,845.4	15,104.6	31.2
70	Тээврийн хэрэгслийн татвар	10,950.0	3,371.9	7,578.1	30.8
71	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,150.0	44.0	2,106.0	2.0
72	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	59,738.1	21,675.4	38,062.7	36.3
73	Газрын төлбөр	52,150.0	40,689.0	11,461.0	78.0
74	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	30,000.0	17,140.1	12,859.9	57.1
75	Бараа үйлчилгээний бусад зардал	23,792,860.7	21,694,764.8	2,098,095.9	91.2
76	Бараа үйлчилгээний бусад зардал	23,303,382.7	21,327,146.6	1,976,236.1	91.5
77	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	489,478.0	367,618.3	121,859.8	75.1
78	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	150,086,149.1	134,092,364.5	15,993,784.7	89.3
79	Засгийн газрын урсгал шилжүүлэг	148,098,779.8	133,291,646.9	14,807,132.9	90.0
80	Засгийн газрын дотоод шилжүүлэг	148,098,779.8	133,291,646.9	14,807,132.9	90.0
81	Бусад урсгал шилжүүлэг	1,987,369.3	800,717.6	1,186,651.8	40.3
82	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	941,000.0	60,000.0	881,000.0	6.4
83	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	270,047.3	221,464.6	48,582.7	82.0
84	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	776,322.0	519,252.9	257,069.1	66.9
<b>85</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>57,428,431.2</b>	<b>37,305,143.1</b>	<b>20,123,288.1</b>	<b>65.0</b>
86	Барилга байгууламж	47,516,587.6	30,879,999.9	16,636,587.7	65.0
87	Их засвар	4,939,851.3	2,962,317.5	1,977,533.8	60.0
88	Тоног төхөөрөмж	4,326,342.3	3,462,825.6	863,516.7	80.0
89	Бусад хөрөнгө	645,650.0	-	645,650.0	-
90	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	(1,908,692.2)	21,569,631.8	(23,478,324.0)	(1,130)
91	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,908,692.2	(21,569,631.8)	23,478,324.0	(1,130)
92	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	1,908,692.2	(21,569,631.8)	23,478,324.0	(1,130)
93	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	8,866,923.9	(8,866,923.9)	-
94	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	31,340,036.1	(31,340,036.1)	-
95	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	8.0	8.0	-	100.0
96	БАЙГУУЛЛАГЫН ТОО	8.0	8.0	-	100.0
<b>97</b>	<b>Төсвийн байгууллага</b>	<b>1,325.0</b>	<b>1,293.0</b>	<b>32.0</b>	<b>97.6</b>

98	АЖИЛЛАГСДЫН ТОО	68.0	66.0	2.0	97.1
99	Удирдах ажилтан	369.0	350.0	19.0	94.9
100	Гүйцэтгэх ажилтан	227.0	227.0	-	100.0
101	Үйлчлэх ажилтан	661.0	650.0	11.0	98.3

## 2.6 Аудит хийсэн нэгдсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /мянган төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Дүн
<b>1</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>3,640,006.2</b>
<b>2</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>1,363,549.4</b>
<b>3</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>1,363,549.4</b>
<b>4</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>13,564.0</b>
5	Бичиг хэрэг	250.0
6	Тээвэр, шатахуун	390.0
7	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,600.0
8	Ном, хэвлэл	960.0
9	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	10,364.0
<b>10</b>	<b>Нормативд зардал</b>	<b>59,756.1</b>
11	Хоол, хүнс	59,756.1
<b>12</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>42,991.0</b>
13	Багаж, техник, хэрэгсэл	42,991.0
<b>14</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>1,213,019.3</b>
15	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	1,213,019.3
<b>16</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>8,415.0</b>
17	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	8,415.0
<b>18</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>25,804.0</b>
<b>19</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>25,804.0</b>
20	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	25,804.0
<b>21</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>2,276,456.8</b>
<b>22</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>2,276,456.8</b>
23	Барилга байгууламж	2,276,456.8
<b>24</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>4,553,556.5</b>
<b>25</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>4,553,556.5</b>
26	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	247,659.4
27	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,126,410.1
28	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	179,487.0
29	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	913,550.3

### 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар хэрэгжүүлэх горим сорилыг төсвийн шатлалд хамаарах байгууллага, нэгж тус бүрээр төлөвлөж хэрэгжүүлсэн бөгөөд аудитын дүн, дүгнэлтийг нэгтгэсэн байдлаар үнэлж гаргалаа.

Нийслэлийн Баянзүрх дүүргийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 11 төсвийн байгууллага, сан, зардал, 6 ОНӨТҮГ-ын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 17 байгууллага, сан, зардал аудитад хамрагдсан. Үүнд: Орон нутгийн төсвийн 11 байгууллага /ИТХ, ЗДТГ, Худалдан авах ажиллагааны алба, Дотоод аудитын алба, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих төв, Соёлын ордон, Гачуурт тосгоны Засаг даргын Тамгын газар /, 3 сан, зардал /хот тохижуулах зардал, ОНХС, Дүүргийн хөрөнгө оруулалтын зардал/, 6 ОНӨТҮГ /Баянзүрх дүүргийн Усан спорт сургалтын төв, Баянзүрх дүүргийн Хөрөнгө оруулалт, бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ, Баянзүрх дүүргийн Хөгжлийн төв ОНӨТҮГ, Баянзүрх дүүргийн Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн ОНӨТҮГ, Баянзүрх Эко тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ, Баянзүрх Шижир амралт ОНӨТҮГ/ -ын санхүүгийн тайланг хамруулж, аудитын горим, сорилыг хэрэгжүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудит хийсэн хэлбэрийг дараах хүснэгтээр үзүүлэв.

№	Байгууллагын ангилал	НТАГ-аас дүгнэлт гаргасан	Аудитын хуулийн этгээдээр гэрээгээр хийлгэж дүгнэлт гаргасан	Үе шатны ажлыг хэсэгчлэн хийсэн	Аудитад хамрагдаагүй
1	ТШЗ	2	-	9	-
2	ОНӨААН	-	3	3	-
	<b>Дүн</b>	<b>2</b>	<b>3</b>	<b>12</b>	

Аудитад хамрагдсан харьяа байгууллагуудын санхүүгийн тайланд “Зөрчилгүй” 3 /ИТХ, Баянзүрх дүүргийн Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв ОНӨТҮГ, Баянзүрх Эко тохижилт үйлчилгээ ОНӨТҮГ /, “Хязгаарлалттай” 2 /ЗДТГ, Баянзүрх Шижир амралт ОНӨТҮГ / дүгнэлт өгсөн.

#### Санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын эрхлэх хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,215,457.1 мянган төгрөгийн 9 алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 127,221.3 мянган төгрөгийн 10 төлбөрийн акт тогтоож, 1,082,194.8 мянган төгрөгийн 6 албан шаардлага хүргүүлж, 3,389,103.1 мянган төгрөгийн 32 зөвлөмж өгсөн.

#### Дөрөв. Төсвийн төвлөрүүлэн захирагчийн ангиллаар аудитад хамрагдсан байдал ба санал дүгнэлтийн талаарх мэдээллийн нэгтгэл

№	Төсвийн захирагчийн ангилал	Байгууллага, нэгжийн тоо				Санал дүгнэлтийн хэлбэр			
		Аудитад хамрагдах	Үүнээс: Аудит хийсэн хэлбэр			Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	Дүгнэлт өгөхөөс татгалзсан
			Санал дүгнэлт гаргасан	Түүвэрт хамруулсан	Аудит хийгээгүй				
А	1	2	3	4	5	7	8	9	10
1	ТТЗ	1	1			1			
	<b>НИЙТ</b>	<b>1</b>	<b>1</b>			<b>1</b>			

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	6	30,410.0	4	22,798.2	2	7,611.8	6	30,410.0				
Засаг даргын Тамгын газар	3	1,185,047.1	1	28,920.0	2	1,156,127.1	3	1,185,047.1				
<b>Орон нутгийн байгууллагын дүн</b>	<b>9</b>	<b>1,215,457.1</b>	<b>5</b>	<b>51,718.2</b>	<b>4</b>	<b>1,163,738.9</b>	<b>9</b>	<b>1,215,457.1</b>	-	-	-	-

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Засаг дарга	7	2,382,587.4	-	-	2	553,600.0	5	1,828,987.4				
<b>ТТЗ-ын дүн</b>	<b>7</b>	<b>2,382,587.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>2</b>	<b>553,600.0</b>	<b>5</b>	<b>1,828,987.4</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>	<b>-</b>
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	7	59,519.2	4	17,257.9			3	42,261.3				
Засаг даргын Тамгын газар	14	1,164,621.1	4	80,594.7	-	-	10	1,084,026.4				
Гачуурт тосгоны ЗДТГ	1	2,029.4	1	2,029.4								
Хөрөнгө оруулалт	-	-										
Орон нутгийн хөгжлийн сан	-	-										
Барьцаа хөрөнгө	2	43,593.1	1	27,339.3			1	16,253.8				
Дотоод аудит	-	-										
Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих төв	3	19,737.6					3	19,737.6				

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Худалдан авах ажиллагааны алба	-	-										
Соёлын төв	1	42,000.0					1	42,000.0				
Хот тохижуулах зардал	2	285,194.3			1	235,315.9	1	49,878.4				
<b>Орон нутгийн байгууллагын дүн</b>	<b>30</b>	<b>1,616,694.7</b>	<b>10</b>	<b>127,221.3</b>	<b>1</b>	<b>235,315.9</b>	<b>19</b>	<b>1,254,157.5</b>	-	-	-	-
Усан спорт сургалтын төв	3	294,774.8					3	294,774.8				
Хөгжлийн төв	-	-										
Олон улсын эко цэцэрлэгт хүрээлэн	1	11,183.4					1	11,183.4				
Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв	2	-					2	-				
Баянзүрх Шижир	3	145,372.7			2	145,372.7	1					
Эко тохижилт үйлчилгээ	2	147,906.2			1	147,906.2	1					
<b>ОНӨААТҮГ-уудын дүн</b>	<b>11</b>	<b>599,237</b>	-	-	<b>3</b>	<b>293,278.9</b>	<b>8</b>	<b>305,958</b>	-	-	-	-
<b>Бүгд дүн</b>	<b>48</b>	<b>4,598,519.2</b>	<b>10</b>	<b>127,221.3</b>	<b>6</b>	<b>1,082,194.8</b>	<b>32</b>	<b>3,389,103.1</b>	-	-	-	-

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
<i>Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил</i>								
Засаг дарга	3	2,765,951.1			3	2,765,951.1		
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	3	210,087.2			3	210,087.2		
Засаг даргын Тамгын газар	1	628,817.0			1	628,817.0		
Хот тохижуулах зардал	1	751,108.0			1	751,108.0		
Соёлын төв	1	29,000.0					1	29,000.0

Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,  
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

<b>Орон нутгийн байгууллагын дүн</b>	<b>9</b>	<b>4,384,963.3</b>	-	-	<b>8</b>	<b>4,355,963.3</b>	<b>1</b>	<b>29,000.0</b>
Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв	1	15,647.2			1	15,647.2		
Баянзүрх Шижир	-	-			-	-	-	-
<b>ОНӨААТҮГ-уудын дүн</b>	<b>1</b>	<b>15,647.2</b>	-	-	<b>1</b>	<b>15,647.2</b>	-	-
<b>Нийт дүн</b>	<b>10</b>	<b>4,400,610.5</b>	-	-	<b>9</b>	<b>4,371,610.5</b>	<b>1</b>	<b>29,000.0</b>
<i>Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил</i>								
Иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	-			-	-	1	
Засаг даргын Тамгын газар	5	6,348,465.7			5	6,348,465.7		
Хот тохижуулах зардал	1	1,959,999.0			1	1,959,999.0		
<b>Орон нутгийн байгууллагын дүн</b>	<b>7</b>	<b>8,308,464.7</b>	-	-	<b>6</b>	<b>8,308,464.7</b>	<b>1</b>	-
Хөрөнгө оруулалт бүтээн байгуулалтыг дэмжих төв	4	13,624,983.4					4	13,624,983.4
Баянзүрх Шижир	6	105,540.9			3	-	3	105,540.9
<b>ОНӨААТҮГ-уудын дүн</b>	<b>10</b>	<b>13,730,524.3</b>	-	-	<b>3</b>	-	<b>7</b>	<b>13,730,524.3</b>
<b>Нийт дүн</b>	<b>17</b>	<b>22,038,989.0</b>	-	-	<b>9</b>	<b>8,308,464.7</b>	<b>8</b>	<b>13,730,524.3</b>
<b>Бүгд дүн</b>	<b>27</b>	<b>26,439,599.5</b>	-	-	<b>18</b>	<b>12,680,075.2</b>	<b>9</b>	<b>13,759,524.3</b>



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 589/А0260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/002/НА-СТА-113

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтаар дүүргийн Ерөнхий боловсролын сургуулиудад автобус нийлүүлэхээр 2 автобусыг 394,000,000.00 (гурван зуун ерэн дөрвөн сая) төгрөгөөр авч, олгохдоо сургуульд биш төрийн бус ахмадын хороо, нийгмийн даатгалын сангаас санхүүждэг дүүргийн нэгдсэн эмнэлэгт тус тус өгсөн, одоогийн байдлаар автобус нь тус газруудад ашиглалтгүй байгаа зэрэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөж, эдийн засгийн ач холбогдол, нэн шаардлагатай эсэхийг тооцохгүйгээр хөрөнгө авч, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6.4.2-д "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хөрөнгө оруулалтын үр өгөөж, эдийн засгийн ач холбогдол, нэн шаардлагатай эсэхийг тооцохгүйгээр хөрөнгө авч, үрэлгэн зарцуулсан, ашиглалтгүй хөрөнгө бэлтгэдэг зэрэг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091101

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, Засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Энхмэнд, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогч Б.Аюуш нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 590/Авс260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/002/НА-СТА-ТТ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтаар дүүргийн бүх цэцэрлэгүүдэд 159,600,000.00 (нэг зуун тавин есөн сая зургаан мянган) төгрөгийн 6000 ширхэг хавтас бэлтгэн нийлүүлж төсвийн хөрөнгийг зориулалтын бус, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", 6.4.2-д "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх" 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д "Төсвийг зориулалт бусаар зарцуулсан" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Дүүргийн хөрөнгө оруулалтаар улсын төсвөөс санхүүждэг, тусдаа төсөвтэй байгууллагуудад хавтас олгосон, зориулалт бус зарцуулалтыг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, Засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Энхмэнд, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогч Б.Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091099



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 09 сарын 25 өдөр

Дугаар 591/А0260191

Улаанбаатар хот

НТНГ-2026/002/НА-СТН-ТТЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр улсын төсвийн сургууль, цэцэрлэгүүдэд 515,482,000.00 хичээлийн хэрэглэгдэхүүн их хэмжээгээр авч, өгсөн нь төлөвлөлт зохион байгуулалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх", Төсвийн тухай хуулийн 5 дугаар 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6.4.2-д "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 6 дугаар зүйлийн 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвөөс санхүүждэг, тусдаа төсөвтэй сургууль, цэцэрлэгүүдэд олгосон хөрөнгө оруулалт, тусалцааг зогсоож, биелэлтийг 2025 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, Засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Энхмэнд, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогч Б.Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091097



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 592/А0260191

Улаанбаатар хот

НТАГ-2026/002/НА-СТА-ТТ3

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Улсын төсвөөс санхүүждэг дүүргийн цагдаа, прокурор, татвар, онцгой байдал, хүүхэд гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, газруудад хөрөнгө оруулалтаар нийт 1,323,492,100.00 (нэг тэр бум гурван зуун хоёр гурван сая дөрвөн зуун ерэн хоёр мянга нэг зуун) төгрөгийн тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил зэвч өгсөн нь төлөвлөлт зохион байгуулалтгүй, төсвийн хөрөнгийг үр ашиггүй, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар 5.1.2-д "төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх", 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 6.4.2-д "төрийн болон орон нутгийн чиг үүрэгт хамаарахгүй хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхгүй байх", 6.6.6-д "тухайн шатны төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргийг зөвхөн тухайн шатны төсвийн санхүүжилтээр хэрэгжүүлэх" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Улсын төсвөөс санхүүждэг тусдаа төсөвтэй байгууллагуудад олгосон хөрөнгө оруулалтыг зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын газрын дарга Д.Бат-Өлзий, Засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Энхмэнд, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогч Б.Аюуш нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР

Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091095



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 05 сарын 05 өдөр

Дугаар 593/АД210191

Улаанбаатар хот

НТАГ-2026/002/НА-СТА-113

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөрөнгө оруулалтын үр өгөөж, эдийн засгийн ач холбогдол, нэн шаардлагатай эсэхийг тооцохгүйгээр их хэмжээтэй компьютер, принтер 789,897,000.00 (долоон зуун наян есөн сая найман зуун ерэн долоон мянган) төгрөг, сүү боловсруулах, зайрмаг хийх тоног төхөөрөмжид 137,100,000.00 (нэг зуун гучин долоон сая нэг зуун мянган) төгрөг нийт 926,997,000.00 (есөн зуун хорин зургаан сая есөн зуун ерэн долоон мянган) хөрөнгө авч, үрэлгэн зарцуулсан байна.

Энэ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.10.2-д "санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон, шаардлагатай хөрөнгө оруулалтын хэмжээг урьдчилан тооцсон, хариуцах эзэнтэй, техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв нь батлагдсан, тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай төсөл, арга хэмжээг эрэмбэлсэн байх", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.7-д "аливаа үйл ажиллагааны зохион байгуулалт нь өртөг зардлын бодит тооцоолол, баталсан стандарт, хэрэгцээ, шаардлагад үндэслэгдсэн байх" гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д "Шалгаадагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-д "Хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Их хэмжээгээр хөрөнгө бэлтгэсэн, үрэлгэн зардал гаргасан зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны дотор Нийслэл дэх Төрийн аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянзүрх дүүргийн Засаг даргын тамгын

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар

1426091093

газрын дарга Д.Бат-Өлзий, Засаг даргын тамгын газрын санхүү төрийн сангийн хэлтсийн дарга Н.Энхмэнд, хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сангийн нягтлан бодогч Б.Аюуш нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
АХЛАХ АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ  
Я.АЛТАНЦЭЦЭГ  
Н.БАТТОГОО

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, А.Амарын гудамж, Соёлын төв өргөө,  
Г корпус, 5 давхар